



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
2017 ОНЫ ЭХНИЙ 9 САР

Улаанбаатар хот

2017 он

Агуулга

<i>Оршил</i>	4
1. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ.....	6
1.1. ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо	7
1.2. Эдийн засгийн салбаруудын үйлдвэрлэл	8
1.3. Бүтээгдэхүүний татвар, татаас	16
2. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ	17

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр	6
Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	6
Хүснэгт 3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо, пунктээр	7
Хүснэгт 4. Ургац хураалт	9
Хүснэгт 5. Бойжуулсан төл, том малын зүй бус хорогдол	9
Хүснэгт 6. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	9
Хүснэгт 7. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	10
Хүснэгт 8. Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт	10
Хүснэгт 9. Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	11
Хүснэгт 10. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	12
Хүснэгт 11. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр.....	12
Хүснэгт 12. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ	13
Хүснэгт 13. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	14
Хүснэгт 14. Шуудан, холбооны салбарын үндсэн үзүүлэлт.....	15
Хүснэгт 15. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр	15
Хүснэгт 16. Хүүгийн орлого, зарлага.....	16
Хүснэгт 17. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого	16
Хүснэгт 18. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр	17
Хүснэгт 19. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	18
Хүснэгт 20. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд	20

Зургийн жагсаалт

Зураг 1. ДНБ-ий өсөлт (%).....	5
Зураг 2. ДНБ-ий өсөлт дэх оролцоо, 2017 оны эхний 9 сар (пункт).....	5
Зураг 3. ДНБ-ий зардлын өсөлт (%)	5
Зураг 4. ДНБ-ий өсөлт дэх оролцоо, 2017 оны эхний 9 сар (пункт).....	5
Зураг 5. ДНБ-ий өсөлт, уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, хувиар	7
Зураг 6. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий өсөлт, хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)	8
Зураг 7. ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-д салбаруудын оролцоо, өсөлт, бууралт.....	8
Зураг 8. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, импорт.....	12
Зураг 9. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ.....	13
Зураг 10. Тээврийн салбарын орлого	14
Зураг 11. Бүтээгдэхүүний татвар, төрлөөр, тэрбум төгрөгөөр	17
Зураг 12. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар.....	18
Зураг 13. ДНБ-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо.....	19

Товчилсон үг

АХС	Ажиллах хүчний судалгаа
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮ	Нийт үйлдвэрлэл
НӨ	Нэмэгдэл өртөг
ӨҮАББ	Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Тайлбар

* Урьдчилсан гүйцэтгэл

ДНБ-ий 2013-2015 оны тоо мэдээллийг Нөөц, ашиглалтын хүснэгтийн 2013-2015 оны үр дүнгээр тодотгосон

Оршил

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.


ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно. Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг эцсийн ашиглалтын; ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар (үйлдвэрлэл, импортын татвар, татаасын зөрүү), үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ийг улирлаар үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцно. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ нь шинээр бий болсон нэмэгдэл өртөг аль салбарт бий болсныг харуулах бол эцсийн ашиглалтын аргаарх ДНБ нь үйлдвэрлэгчдийн бий болгосон нэмэгдэл өртгийг зах зээлийн арилжаа солилцооны эцэст хаана, ямар хэлбэрийн өртөг болгож ашигласныг харуулна. Энэ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

ДНБ 2017 оны эхний 9 сард 5.8% өслөө

Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ 2017 оны эхний хагас жилд өмнөх оноос 5.3 хувиар өссөн бол эхний 9 сард өмнөх оноос 5.8 хувиар өслөө.

Зураг 1. ДНБ-ий өсөлт (%)



ДНБ-ий эхний 9 сарын өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн салбар бол худалдааны салбар бөгөөд уг салбарын нэмэгдэл өртөг (НӨ) өмнөх оноос 17.2 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.9 пунктийг бүрдүүлсэн байна.


Боловсруулах салбарын НӨ 22.7 хувиар өссөн бөгөөд ДНБ-ий өсөлтөд 1.2 пунктийн оролцоотой байна. Харин уул уурхай, олборлох салбарынх 1.9 хувиар буурч, ДНБ-ий өсөлтөд (-0.5) пунктийн оролцоотой байна.

Зураг 2. ДНБ-ий өсөлт дэх оролцоо, 2017 оны эхний 9 сар (пункт)




Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ 2017 оны эхний хагас жилд өмнөх оноос 5.2 хувиар өссөн бол эхний 9 сард өмнөх оноос 5.7 хувиар өслөө.

Зураг 3. ДНБ-ий зардлын өсөлт (%)



Өрхийн аж ахуйн эцсийн хэрэглээ 2017 оны эхний 9 сард 4.1 хувиар өссөн, энэ нь ДНБ-ий нийт өсөлтөд 2.3 пунктийн оролцоотой байна. Төрийн байгууллагын хэрэглээ 7.6 хувиар буурч, нийт өсөлтөд 1.1 пунктийн оролцоотой байна. Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 32.1 хувийн өсөлттэй бөгөөд нийт өсөлтөд 5.7 пунктийг бүрдүүлсэн байна. Экспорт 18.8 хувь, импорт 27.5 хувиар нэмэгдэж, цэвэр экспорт нийт өсөлтийн (-5.7) пунктийг бүрдүүлжээ.

Зураг 4. ДНБ-ий өсөлт дэх оролцоо, 2017 оны эхний 9 сар (пункт)



1. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ

➤ ДНБ, оны үнээр

ДНБ, оны үнээр 2017 оны эхний 9 сард 19.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 (15.2%) их наяд төгрөгөөр өслөө.

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

	2014	2015	2016 ¹	2017*	<u>2014 I-IX</u>	<u>2015 I-IX</u>	<u>2016¹ I-IX</u>	<u>2017* I-IX</u>
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2013 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 ¹ I-IX
	тэрбум төгрөг				хувиар			
ДНБ	16 559.2	17 148.9	17 246.9	19 875.1	119.4	103.6	100.6	115.2
Хөдөө аж ахуй	2 410.9	2 570.1	2 353.5	2 443.1	125.6	106.6	91.6	103.8
Уул уурхай, олборлолт	2 812.7	2 687.1	2 995.4	4 291.3	127.1	95.5	111.5	143.3
Аж үйлдвэр, барилга	2 410.8	2 259.2	2 230.3	2 453.9	111.7	93.7	98.7	110.0
Үйлчилгээ	7 247.8	8 132.9	8 081.8	8 676.4	122.5	112.2	99.4	107.4
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1 677.1	1 499.5	1 585.9	2 010.4	100.9	89.4	105.8	126.8

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

*урьдчилсан гүйцэтгэл

➤ ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр


ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 оны эхний 9 сард 12.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.7 (5.8%) их наяд төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 0.3 (7.2%) их наяд төгрөг, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.2 (19.5%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2014	2015	2016 ¹	2017*	<u>2014 I-IX</u>	<u>2015 I-IX</u>	<u>2016¹ I-IX</u>	<u>2017* I-IX</u>
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2013 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 ¹ I-IX
	тэрбум төгрөг				хувиар			
ДНБ	11 295.1	11 550.1	11 391.8	12 056.3	109.1	102.3	98.6	105.8
Хөдөө аж ахуй	1 523.3	1 679.6	1 749.3	1 827.8	125.0	110.3	104.1	104.5
Уул уурхай, олборлолт	2 367.1	2 681.9	2 670.3	2 619.0	121.3	113.3	99.6	98.1
Аж үйлдвэр, барилга	1 243.4	1 219.2	1 132.3	1 213.9	97.5	98.1	92.9	107.2
Үйлчилгээ	4 755.2	4 810.0	4 723.6	5 062.1	109.0	101.2	98.2	107.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1 406.1	1 159.5	1 116.3	1 333.6	90.9	82.5	96.3	119.5

Зураг 5. ДНБ-ий өсөлт, уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, хувиар

ДНБ-ий эхний 9 сарын өсөлтийг уул уурхайн болон уул уурхайн бус салбарын гэж ангилан харуулбал, 2014-2016 онд уул уурхайн салбар 8.6-17.0 хувиар өссөн байна. Харин 2017 оны эхний 9 сард уул уурхайн салбар хэдийгээр 1.9 хувийн бууралттай байсан ч эдийн засаг 5.8 хувиар өслөө.



1.1. ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо

Хүснэгт 3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо, пунктээр

	2015				2016 ¹				2017*		
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX
ДНБ-ий өсөлт, %	4.2	3.2	2.3	2.4	3.0	1.5	-1.4	1.2	4.2	5.3	5.8
Хөдөө аж ахуй	0.4	1.5	1.4	1.3	0.2	0.7	0.6	0.8	0.2	0.6	0.7
Уул уурхай, олборлолт	3.0	3.3	2.8	3.2	3.8	1.9	-0.1	0.0	-1.7	-1.4	-0.5
Боловсруулах	0.6	0.3	0.2	0.2	-0.7	-0.7	-0.4	-0.1	1.2	1.1	1.2
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.2	0.1	0.0	0.1	0.1	0.1	0.0	0.0	0.1	0.1	0.1
Барилга	0.2	0.0	-0.5	0.0	0.4	0.2	-0.4	-0.2	-0.5	-0.6	-0.6
Бөөний, жижиглэн худалдаа	-1.3	-1.4	-1.4	-1.1	-0.4	0.1	-0.8	-0.3	2.5	1.9	1.9
Тээвэр, мэдээлэл, холбоо	0.0	-0.4	-0.6	0.3	-0.3	0.0	0.1	0.7	0.6	0.9	0.4
Үйлчилгээний бусад	3.1	1.8	2.4	1.2	0.2	0.1	0.0	0.2	0.1	0.5	0.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-2.1	-2.2	-2.2	-2.5	-0.2	-0.9	-0.4	0.0	1.9	2.2	1.9

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоог авч үзвэл 2015, 2016 онуудад ДНБ-ий өсөлтийн дийлэнх хувийг уул уурхай, олборлох салбар дангаараа хангаж байсан бол 2017 оны хувьд нүүрс олборлолтын салбарын үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой бусад салбаруудад өсөлт гарсан байна. Тухайлбал, нүүрсний тээвэрлэлт нэмэгдснээс шатахууны худалдаа өсжээ. Түүнчлэн боловсруулах салбар болон бүтээгдэхүүний татварт өсөлт гарсан байна.

Хүснэгт 4. Ургац хураалт

	2014	2015	2016	2016 XI.1	2017 XI.1	<u>2017 XI.1</u> 2016 XI.1
	мянган тонн					хувь
Үр тариа	518.8	216.3	483.5	483.3	231.3	47.9
Төмс	161.5	163.8	165.3	154.2	121.3	78.7
Хүнсний ногоо	104.8	72.3	94.4	90.9	80.5	88.6
Хадлан	1 178.7	1 028.7	1 275.4	1 155.7	911.8	78.9

Мал аж ахуйн салбарын хувьд 2017 онд нийт 22.6 сая толгой мал бойжуулж, том малын зүй бус хорогдлыг 0.8 сая толгой, нийт 14.5 сая толгой мал хүнсэнд хэрэглэнэ гэж тооцооллоо. Үүний үр дүнд мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл жилийн дүнгээр 7.3 хувиар өсөхөөр байна.

Хүснэгт 5. Бойжуулсан төл, том малын зүй бус хорогдол

Үзүүлэлт	2014	2015	2016	2016 I-IX	2017* I-IX	<u>2017*</u> 2016
	мянган толгой					хувь
Малын тоо, оны эхэнд	45 144.3	51 982.5	55 979.7			
Бойжуулсан төл	17 246.0	19 179.5	19 721.7	19 175.7	22 010.9	114.8
Том малын зүй бус хорогдол	401.4	625.6	1 452.1	1 263.2	622.2	49.3
Хүнсэнд хэрэглэсэн мал	10 006.4	14 556.7	12 700.0			
Малын тоо, оны эцэст	51 982.5	55 979.7	61 549.3			

➤ Аж үйлдвэрийн салбар

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2017 оны эхний 9 сард ДНБ-ий өсөлтийн 0.8 пунктийг бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл (оны үнээр) 2017 оны эхний 9 сард 9409.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2562.1 (37.4%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Аж үйлдвэрийн салбар	2014	2015	2016	2017	<u>2015 I-IX</u>	<u>2016 I-IX</u>	<u>2017 I-IX</u>
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX
	тэрбум төгрөг				хувь		
Нийт дүн	6 629.5	6 387.8	6 847.0	9 409.1	96.4	107.2	137.4
Уул уурхай, олборлох	4 582.1	4 309.6	4 798.1	6 886.3	94.1	111.3	143.5
Боловсруулах	1 610.9	1 555.6	1 432.2	1 874.1	96.6	92.1	130.9
Цахилгаан, дулаан, ус хангамж	436.4	522.6	616.6	648.6	119.7	118.0	105.2

➤ Уул уурхай, олборлох салбар

Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 9 сард 6886.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2088.2 (43.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017* I-IX	Бүтэц		
					2015 I-IX	2016 I-IX	2017* I-IX
	тэрбум төгрөг				хувь		
Нийт дүн	4 582.1	4 309.6	4 798.1	6 886.3	100.0	100.0	100.0
Нүүрс олборлолт	516.7	592.7	743.5	1 845.4	13.7	15.5	26.8
Газрын тос олборлолт	965.6	627.0	503.8	674.4	14.5	10.5	9.8
Металлын хүдэр олборлолт	3 032.7	3 032.9	3 496.2	4 298.8	70.4	72.9	62.4
Бусад ашигт малтмал олборлолт	67.2	57.0	54.6	67.8	1.3	1.1	1.0

Нүүрс олборлолтын хэмжээ 2017 оны эхний 9 сард 36.2 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 14.7 (68.3%) сая тонноор, нүүрсний экспортын хэмжээ 2017 оны эхний 9 сард 25.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 9.5 (58.6%) мянган тонноор өсжээ. Хайлуур жоншны хувьд 2017 оны эхний 9 сард олборлолт өмнөх оны мөн үеэс 39.3 хувиар буурч, экспорт 14.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт

	2016			2017			2017/2016		
	I-III	I-VI	I-IX	I-III	I-VI	I-IX	I-III	I-VI	I-IX
Нүүрс, мян.т	5 346.3	12 760.4	21 489.8	11 698.1	24 837.2	36 176.5	218.8	194.6	168.3
Газрын тос, мян.бар	2 314.2	4 368.1	6 161.2	1 815.0	3 738.7	5 720.2	78.4	85.6	92.8
Зэсийн баяжмал, мян.т	379.9	734.0	1 088.4	322.3	647.6	960.0	84.8	88.2	88.2
Молибдений баяжмал, тн	1 180.1	2 501.9	3 606.1	1 457.5	2 878.4	4 194.5	123.5	115.0	116.3
Алт, кг	1 809.8	6 495.4	13 957.5	2 057.1	6 666.1	14 771.6	113.7	102.6	105.8
Төмрийн хүдэр, баяжмал, мян.т	133.9	2 242.4	4 717.1	1 057.4	4 566.5	8 578.3	789.7	203.6	181.9
Цайрын хүдэр, баяжмал, мян.т	21.8	42.6	76.9	20.6	40.0	60.6	94.5	93.9	78.8

➤ *Боловсруулах салбар*

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 9 сард 1874.1 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 441.9 (30.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Дэд салбар гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2015	2016	2017	2016 I-IX	2017 I-IX
	I-IX	I-IX	I-IX	2015 I-IX	2016 I-IX
	тэрбум төгрөг			хувь	
Нийт дүн	1 579.9	1 432.2	1 874.1	90.7	130.9
Хүнс, ундаа үйлдвэрлэл	739.2	750.1	863.6	101.5	115.1
Малын мах, мян.т	6.7	3.5	10.9	52.2	3.1 ¹
Гурил, мян.т	134.1	122.7	138.6	185.5	113.0
Спирт, сая л	6.1	6.1	6.4	100.0	104.9
Архи, сая л	15.4	17.4	17.8	113.0	102.3
Шар айраг, сая л	58.7	58.4	63.7	99.5	109.1
Тамхи үйлдвэрлэл	41.8	12.4	16.3	29.8	131.3
Тамхи, мян.блок	2 895.0	3 089.8	3 651.7	106.7	118.2
Нэхмэлийн үйлдвэрлэл	281.6	338.5	332.5	120.2	98.2
Хивс, мян.м2	522.7	329.8	351.3	63.1	106.5
Самнасан ноолуур, т	469.6	600.6	754.2	127.9	125.6
Эсгий, мян.м	114.2	67.9	74.5	59.5	109.7
Хувцас үйлдвэрлэл	23.2	15.8	29.5	68.3	186.5
Нэхий дээл, ш	3 719.0	5 105.0	11 444.0	137.3	2.2 ¹
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал	12.9	7.6	12.7	58.9	166.8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	4.2	7.1	10.3	168.7	145.8
Зүсмэл материал, мян.м3	11.7	7.8	7.5	66.7	96.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5.8	6.6	11.0	113.2	166.9
Нийтлэх, хэвлэх үйл ажиллагаа	19.3	20.4	18.5	105.9	90.8
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	161.6	54.0	258.3	33.4	4.8 ¹
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	35.9	35.5	57.8	98.9	162.7
Резин, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	28.1	17.2	13.6	61.2	79.3
Вакуум цонх, хаалга, мян.м2	47.7	24.1	22.5	50.5	93.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	76.2	71.4	109.3	93.7	153.1
Цемент, мян.т	349.7	353.5	556.5	101.1	157.4
Шохой, мян.т	38.6	32.2	39.7	83.5	123.1
Төмрийн үйлдвэрлэл	126.8	85.5	126.6	67.4	148.0
Металл бэлдэц, мян.т	31.5	12.5	15.5	39.7	124.0
Катодын зэс, мян.т	11.4	11.2	10.9	98.2	97.3
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	10.9	2.0	5.0	18.8	2.4 ¹
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	0.1	0.3	0.3	334.9	76.5
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	0.9	1.0	1.0	106.0	108.8
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2.1	2.0	2.6	94.3	132.6
Тавилга үйлдвэрлэл, бусад	9.7	4.7	4.9	48.5	103.6

1 – дахин их

➤ *Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбар*

Цахилгаан эрчим хүч болон усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 9 сард 648.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 32.0 (5.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Дэд салбар	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	<u>2016 I-IX</u>	<u>2017 I-IX</u>
	тэрбум төгрөг				хувь	
	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2016 I-IX
Нийт дүн	436.4	522.6	616.6	648.6	118.0	105.2
Цахилгаан, дулаан, уур	399.3	472.6	566.8	593.6	119.9	104.7
Ус ариутгал, усан хангамж	37.1	50.0	49.8	55.0	99.6	110.6

➤ *Барилгын салбар*


Барилга угсралт, их засварын ажил 2017 оны эхний 9 сард оны үнээр 1549.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 11. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр

Барилгын төрөл	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	<u>2016 I-IX</u>	<u>2017 I-IX</u>
	тэрбум төгрөг				хувь	
	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2016 I-IX
Барилга угсралт, их засварын ажил	1 716.5	1 962.1	1 880.3	1 549.1	95.8	82.4
Орон сууцны барилга	669.9	761.7	785.4	721.0	103.1	91.8
Орон сууцны бус барилга	450.9	611.7	639.4	412.9	104.5	64.6
Инженерийн барилга, байгууламж	539.8	547.2	424.4	348.2	77.6	82.1
Их засварын ажил	55.9	41.5	31.1	67.0	74.9	215.4

Зураг 8. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, импорт

Барилга угсралт, их засварын ажил 2017 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар буурсан бол барилгын материалын үйлдвэрлэл оны үнээр 53.1 хувиар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 49.3 хувиар нэмэгдсэн байна.



➤ Бөөний болон жижиглэн худалдааны салбар


Бөөний болон жижиглэн худалдаа (дотоод худалдаа)-ны нийт борлуулалт 2017 оны эхний 9 сард 10194.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1903.0 (23.0%) тэрбум төгрөгөөр өслөө.

Импортын хэмжээ 2017 оны эхний 9 сард 3130.7 сая америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 682.7 (27.9%) сая америк доллараар нэмэгдсэн байна. Импортын эрдэс бүтээгдэхүүний импорт 235.0 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 161.2 сая америк доллар, автобензин 44.8 сая америк доллараар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 136.8 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 135.0 сая америк доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлсийнх 82.8 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 12. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ

	Дотоод худалдааны борлуулалт, тэрбум төгрөг						Импорт, сая америк доллар					
	2014	2015	2016	2017	<u>2016</u> 2015	<u>2017</u> 2016	2014	2015	2016	2017	<u>2016</u> 2015	<u>2017</u> 2016
	тэрбум төгрөг				хувь		тэрбум төгрөг				хувь	
I-III	2 231.7	2 237.2	2 137.9	2 744.8	95.6	128.4	996.0	701.8	599.0	776.2	85.4	129.6
I-VI	5 232.4	5 205.7	5 297.0	6 419.6	101.8	121.2	2 600.8	1 838.7	1 499.1	1 930.6	81.5	128.8
I-IX	9 191.9	9 157.6	8 291.7	10 194.7	90.5	123.0	4 022.7	2 856.8	2 448.0	3 130.7	85.7	127.9
I-XII	12 804.3	13 526.6	13 199.2		97.6		5 236.7	3 797.5	3 358.1		88.4	

Зураг 9. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ



Бөөний болон жижиглэн худалдааны салбар нь манай эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг билээ. Уг салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2017 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.9 пунктийг хангасан байна.

➤ *Тээврийн салбар*


Бүх төрлийн тээврээр 2017 оны эхний 9 сард 35.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 5.1 (16.7%) сая тонноор өссөн байна.

Авто тээврийн тээсэн ачаа 2017 оны эхний 9 сард 19.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 3.0 (18.6%) сая тонноор өссөн байна.

Хүснэгт 13. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2015 I-IX 2014 I-IX	2016 I-IX 2015 I-IX	2017 I-IX 2016 I-IX
	Шилжүүлсэн сая тонн км				хувь		
Бүх төрлийн тээвэр	14 344.7	12 113.8	14 119.2	15 226.7	84.4	116.6	107.8
Авто тээвэр	4 478.0	2 886.6	4 305.7	4 549.2	64.5	149.2	105.7
Төмөр замын тээвэр	9 768.1	9 137.8	9 722.5	10 575.5	93.5	106.4	108.8
Агаарын тээвэр	97.7	88.6	90.6	101.5	90.7	102.3	112.0
	Тээсэн ачаа, мянган тонн				хувь		
Бүх төрлийн тээвэр	33 810.1	27 529.0	30 533.6	35 630.3	81.4	110.9	116.7
Авто тээвэр	18 789.0	13 682.0	16 314.6	19 350.5	72.8	119.2	118.6
Төмөр замын тээвэр	15 018.4	13 844.9	14 216.8	16 277.5	92.2	102.7	114.5
Агаарын тээвэр	2 645.3	2 123.6	2 279.7	2 268.2	80.3	107.4	99.5

Зураг 10. Тээврийн салбарын орлого



➤ *Шуудан, мэдээлэл, холбооны салбар*

Шуудан, холбооны салбарын нийт орлого 2017 оны эхний 9 сард 566.5 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 4.9 (0.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 14. Шуудан, холбооны салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017	2016 I-IX	2017 I-IX
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2015 I-IX	2016 I-IX
					хувь	
Нийт орлого, оны үнээр, тэрбум төг	533.1	549.8	561.6	566.5	102.1	100.9
Хүн амаас орсон орлого, тэрбум төг	388.8	415.4	402.1	393.5	96.8	97.9
Суурин утасны цэгийн тоо, мян.ш	214.1	249.7	267.3	287.8	107.1	107.7
Үүрэн утас хэрэглэгчид, мян.хүн	3 561.9	3 892.5	3 386.7	3 623.9	87.0	107.0
Утасгүй холбооны тоо	890	580	538	500	92.8	92.9
Кабелийн телевиз хэрэглэгчид, мян.	333.3	369.3	407.2	458.7	110.2	112.7

➤ *Үйлчилгээний бусад салбар*

Үйлчилгээний бусад салбарт зочид буудал, нийтийн хоол; санхүү, даатгал; үл хөдлөх хөрөнгө; мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; боловсрол; эрүүл мэнд, нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам; үйлчилгээний бусад үйл ажиллагаа зэрэг салбарыг оруулна.

Үйлчилгээний бусад салбарын нийт нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2017 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 0.,7 пунктийг бүрдүүлжээ.

➤ *Зочид буудал, нийтийн хоолны үйл ажиллагаа*

Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт орлого 2017 оны эхний 9 сард 337.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 52.5 (18.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд нүүрсний салбарын үйл ажиллагаа өссөнтэй холбоотой рестораны орлого 17.4 (17.7%) тэрбум төгрөг, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ 17.8 (53.2%) тэрбум төгрөг, кафены орлого 11.4 (50.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөллөө.

Хүснэгт 15. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр

	2014	2015	2016	2017	2015	2016	2017
					2014	2015	2016
	тэрбум төгрөг				хувь		
I-III	63.4	65.3	65.2	77.2	103.0	99.8	118.4
IV-VI	85.8	84.3	101.3	113.3	98.2	120.2	111.9
VII-IX	99.0	113.9	118.3	146.8	115.1	103.9	124.1
IX-XII	75.4	76.4	82.3		101.3	107.8	
I-XII	323.6	339.8	367.1		105.0	108.0	

➤ *Санхүү, даатгалын салбар*

Банкны салбарын хэмжээнд 2017 оны 9 дүгээр сарын эцэст хүүгийн орлого 1994.2 тэрбум төгрөг, хүүгийн зардал 1386.2 тэрбум төгрөгт хүрснээр хүүгийн цэвэр орлого 608.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 99.7 (19.6%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Хүснэгт 16. Хүүгийн орлого, зарлага

Үзүүлэлтүүд	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	<u>2015 I-IX</u>	<u>2016 I-IX</u>	<u>2017 I-IX</u>
	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX
	тэрбум төгрөг				хувь		
Хүүгийн орлого	1 449.2	1 635.9	1 688.3	1 994.2	112.9	103.2	118.1
Хүүгийн зардал	925.3	1 043.4	1 179.9	1 386.2	112.8	113.1	117.5
Хүүгийн цэвэр орлого	523.9	592.5	508.4	608.1	113.1	85.8	119.6

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 9 дүгээр сарын эцэст 13421.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 930.5 (7.4%) тэрбум төгрөгөөр өсжээ. Нийт хадгаламжийн хэмжээ 2017 оны 9 дүгээр сарын эцэст 10037.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1929.1 (23.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

➤ Төрийн удирдлага, батлан хамгаалах салбар, төсөвт байгууллага

Үйлчилгээний бусад салбарт орсон мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; боловсрол; эрүүл мэнд, нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам зэрэг салбарын нэмэгдэл өртгийн дийлэнх хувь нь төсөвт байгууллагын нэмэгдэл өртөг байдаг. Зах зээлийн бус үйл ажиллагаа буюу төсөвт байгууллагын нэмэгдэл өртөг нь ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого болон байгууллагын үндсэн хөрөнгийн хэрэглээнээс бүрдэнэ. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого 2015 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар нэмэгдэж байсан бол 2016 онд 2.6 хувь, 2017 онд 1.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 17. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого


Орлогын төрөл	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	<u>2015 I-IX</u>	<u>2016 I-IX</u>	<u>2017 I-IX</u>
	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX
	тэрбум төгрөг				хувь		
Цалин, хөлс, түүнтэй адилтгах орлого	1 118.4	1 246.2	1 279.2	1 292.0	111.4	102.7	101.0
Нийгмийн даатгалын шимтгэл	105.3	114.3	116.4	117.0	108.5	101.9	100.5
Бүгд	1 223.7	1 360.4	1 395.6	1 409.0	111.2	102.6	101.0

1.3. Бүтээгдэхүүний татвар, татаас

Бүтээгдэхүүний татвараас татаасыг хассан дүн буюу бүтээгдэхүүний цэвэр татвар нь үнэлгээний үзүүлэлт бөгөөд үндсэн үнээрх ДНБ, бүтээгдэхүүний цэвэр татварын нийлбэрээр зах зээлийн үнээрх /худалдан авагчийн үнээрх/ ДНБ-ийг тооцно. Бүтээгдэхүүний татварын гүйцэтгэл нь бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг. Бүтээгдэхүүний татварт нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний тусгай зориулалтын орлого, гадаад худалдааны татварыг оруулна. Харин бүтээгдэхүүний татааст эрчим хүчний татаас, нийтийн тээврийн татаас, улаанбуудай, махны татаас орно.

Бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2017 оны эхний 9 сард 1333.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.9 пунктийг бүрдүүлжээ. Үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар (оны үнээр) 48.8 хувь, импортын гаалийн албан татвар (оны үнээр) 35.4 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Зураг 11. Бүтээгдэхүүний татвар, төрлөөр, тэрбум төгрөгөөр



2. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ

➤ ДНБ (эцсийн ашиглалтын аргаарх), оны үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ оны үнээр 2017 оны эхний 9 сард 20257.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2907.7 (16.8%) тэрбум төгрөгөөр өслөө.

Хүснэгт 18. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр

Бүрэлдэхүүн	2014 I-IX	2015 I-IX	2016 ¹ I-IX	2017* I-IX	<u>2016¹ I-IX</u>	<u>2017* I-IX</u>
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	16 172.3	17 214.7	17 350.3	20 257.9	100.8	116.8
Эцсийн хэрэглээ	11 739.3	12 739.4	12 107.5	12 672.1	95.0	104.7
Өрхийн аж ахуй, ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал ²	9 798.3	10 548.1	9 530.2	10 291.3	90.3	108.0
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	1 941.0	2 191.3	2 577.3	2 380.8	117.6	92.4
Хөрөнгийн нийт хуримтлал	5 838.9	4 187.8	4 928.1	6 625.9	117.7	134.5
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	4 555.8	3 343.3	3 195.4	4 239.5	95.6	132.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	1 283.1	844.5	1 732.7	2 386.4	205.2	137.7
Цэвэр экспорт	- 1 405.9	287.5	314.7	959.9	109.5	305.1
Экспорт	8 139.1	7 995.8	8 013.8	12 437.0	100.2	155.2
Импорт	9 545.0	7 708.3	7 699.2	11 477.0	99.9	149.1

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо


² Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

³ Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

ДНБ, оны үнээр, 2017 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар өсөхөд экспорт 4423.1 (55.2%) тэрбум төгрөгөөр, хөрөнгийн нийт хуримтлал 1697.8 (34.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөллөө.

Зураг 12. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар

ДНБ-д 2017 оны эхний 9 сард эцсийн хэрэглээ 62.6 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 32.7 хувь, цэвэр экспорт 4.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс хөрөнгийн нийт хуримтлал 4.3 пункт, цэвэр экспорт 2.9 пунктээр өсөж, харин эцсийн хэрэглээ 7.2 пунктээр буурсан байна.



¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

➤ ДНБ (эцсийн ашиглалтын аргаарх), 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 оны эхний 9 сард 12.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 645.0 (5.7%) тэрбум төгрөгөөр өслөө.

Хүснэгт 19. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Бүрэлдэхүүн	2014 I-IX	2015 I-IX	2016 ¹ I-IX	2017* I-IX	<u>2016¹ I-IX</u>	<u>2017* I-IX</u>
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	11 108.0	11 625.4	11 372.7	12 017.7	97.8	105.7
Эцсийн хэрэглээ	8 236.3	8 680.9	8 053.1	8 180.0	92.8	101.6
Өрхийн аж ахуй, ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал ²	6 722.3	7 187.2	6 329.4	6 587.1	88.1	104.1
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	1 514.0	1 493.7	1 723.7	1 592.9	115.4	92.4
Хөрөнгийн нийт хуримтлал	4 069.3	2 825.1	3 201.6	4 230.8	113.3	132.1
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	3 356.4	2 327.0	2 096.7	2 746.2	90.1	131.0
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	712.9	498.2	1 104.9	1 484.5	221.8	134.4
Цэвэр экспорт	- 1 197.6	119.4	118.0	- 393.2	-	-
Экспорт	6 934.7	7 365.4	7 881.3	9 504.1	107.0	120.6
Импорт	8 132.2	7 246.0	7 763.2	9 897.2	107.1	127.5

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо


² Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

³ Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5.7 хувиар өсөхөд экспорт 3245.6 (20.6%) тэрбум төгрөг, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 649.5 (31.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон

Зураг 13. ДНБ-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5.7 хувийн өсөлтийн 1.1 пунктийг эцсийн хэрэглээ, 9.0 пунктийг хөрөнгийн нийт хуримтлал, 14.3 пунктийг экспорт, (-18.8) пунктийг импорт бүрдүүлжээ.



¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

Хүснэгт 20. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017*	2017* I-IX
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2016 I-IX
	тэрбум төгрөг				хувь
ДНБ, оны үнээр	16 559.2	17 148.9	17246.9	19875.1	115.2
ДНБ, 2010 оны үнээр	11 295.1	11 550.1	11 391.8	12 056.3	105.8
ДНБ-ий бодит өсөлт, бууралт, % (өмнөх оны мөн үеийнхээс)	9.1	2.3	-1.4	5.8	-
ХҮУИ, өмнөх оны мөн үеэс, %	13.0	4.9	-0.1	5.8	-
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	4 311.7	4 045.9	4 012.7	5 035.1	125.5
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл	4 504.2	4 913.2	6 064.4	5 773.0	95.2
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	- 192.5	- 867.3	-2 051.7	- 737.9	36.0
Мөнгө M1, хугацааны эцэст	1 836.3	1 613.6	2 020.5	2 801.8	138.7
Мөнгө M2, хугацааны эцэст	10 072.1	9 933.2	11 555.9	14 760.1	127.7
Зээлийн өрийн үлдэгдэл, хугацааны эцэст	12 612.8	11 944.3	12 490.9	13 421.4	107.4
Хадгаламжийн нийт хэмжээ, хугацааны эцэст	6 972.1	7 277.1	8 107.9	10 037.0	123.8
АҮ-ийн нийт үйлдвэрлэл	6 629.5	6 387.8	6 847.0	9 409.1	137.4
Уул уурхай	4 582.1	4 309.6	4 798.1	6 886.3	143.5
Уул уурхайн бус	2 047.4	2 078.2	2 048.9	2 522.8	123.1
Барилга угсралт, их засварын ажил	1 716.5	1 962.1	1 880.3	1 549.1	82.4
Худалдааны борлуулалт	9 191.9	9 157.6	8 291.7	10 194.7	123.0
Шуудан, холбооны орлого	533.1	549.8	561.6	566.5	100.9
Тээврийн нийт орлого	809.4	846.0	916.7	1 027.9	112.1
Шилжүүлсэн сая тонн км	14 344.7	12 113.8	14 119.2	15 226.7	107.8
Авто тээвэр	4 478.0	2 886.6	4 305.7	4 549.2	105.7
Төмөр замын тээвэр	9 768.1	9 137.8	9 722.5	10 575.5	108.8
Агаарын тээвэр	97.7	88.6	90.6	101.5	112.0
Тээсэн ачаа, мянган тонн	33 810.1	27 529.0	30 533.6	35 630.3	116.7
Авто тээвэр	18 789.0	13 682.0	16 314.6	19 350.5	118.6
Төмөр замын тээвэр	15 018.4	13 844.9	14 216.8	16 277.5	114.5
Агаарын тээвэр, тонн	2 645.3	2 123.6	2 279.7	2 268.2	99.5
Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт орлого	248.2	263.3	284.8	337.3	118.4
Гадаад худалдаа, сая америк доллар					
Нийт эргэлт	8 043.9	6 397.6	5 780.4	7 713.6	133.4
Экспорт	4 021.3	3 540.9	3 332.4	4 582.9	137.5
Импорт	4 022.7	2 856.7	2 448.0	3 130.8	127.9
Тэнцэл	- 1.4	684.2	884.4	1 452.1	164.2
Бүтээгдэхүүний татвар					
НӨАТ	1 012.1	759.8	775.3	1 153.8	148.8
Онцгой татвар	345.9	410.9	493.1	360.4	73.1
Гадаад худалдааны татвар	275.4	241.3	233.3	351.3	150.6
Нүүрс:					
Олборлолт, мянган тонн	15 544.5	17 652.8	21 489.8	36 176.5	168.3
Экспорт, мянган тонн	13 490.9	10 504.0	16 245.6	25 773.4	158.6